

БАТЛАВ.

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АЛТАН-ОД



ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН ХҮНИЙ  
НӨӨЦИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН СУДАЛГАА ХИЙХ, ЦААШИД БАРИМТЛАХ  
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны -р сарын ...-ны өдөр

Дугаар 20240203182

Улаанбаатар хот

№	Агуулга	Тайлбар, тодорхойлолт
1.	Зөвлөх үйлчилгээний нэр	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа хийх, цаашид баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах
2.	Захиалагч газар, хэлтсийн нэр	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Бодлого, төлөвлөлтийн газар
3.	Хэрэгжүүлэх хугацаа	Нийт: 45 хоног Эхлэх: Гэрээ байгуулсан өдрөөс эхлэнэ. Дуусах: 2024 оны ..... сарын ....-ны өдөр
4.	Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага	<u>Хууль эрх зүйн үндэслэл:</u> Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” бодлогын баримт бичгийн “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ” зорилтын хүрээнд 2021-2030 он хүртэл мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх талаар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан: - 2.1.28. Нийгэмд нэн чухал боловсрол, эрүүл мэнд, мэдээллийн технологийн болон эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр хүний нөөцийг бэлтгэж, төр, хувийн хэвшлийн дэмжлэг, хамтын ажиллагааны үр нөлөөтэй зохицуулалт бүрдүүлж, стратегийн ач

холбогдол бүхий чиглэлээр гадаадад суралцагчдыг төрөөс дэмжинэ,

- 2.6.8. Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох мэргэжлийн чиглэлээр хүний нөөц бэлтгэх бодлого, “Хиймэл оюун ухаан ба ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ;
- 7.5.5.Цахим мэдээллийг ангилах, тодорхойлох, үнэлэх, төрийн мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн эмзэг, сул байдлыг илрүүлэх, эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж байх талаар холбогдох хууль, дүрэм, журамд тусган онц чухал дэд бүтэц бүхий байгууллагуудад цахим халдлагатай тэмцэх баг бий болгож мэргэшсэн хүний нөөц бэлтгэж, хөгжүүлнэ.

Хэрэгцээ шаардлага:

ХХМТ-ийн салбарын хурдтай хөгжил, ололт, амжилт нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн тулгуур, тэргүүлэх чиглэл болон хөгжиж буйн зэрэгцээ мэдээлэлжсэн нийгмийг байгуулахын тулд чадварлаг мэргэжилтнүүдийг бэлтгэх нь нэн тэргүүний хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Монгол Улсын засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.2 дахь Эрдэм боловсролтой монгол хүн зорилтын 2.2.1.3-т “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг их өгөгдөлд суурилан тооцоолж, шаардлагатай хүний нөөцийг бэлтгэнэ”, 4.3 дахь Цахим засаглал, төрийн бүтээмжийн дахин инженерчлэл зорилтын 4.3.3.6-т “Кибер аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөцийг чадавхжуулж, бүх нийтийн кибер аюулгүй байдлын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлнэ”, 4.4.3.8-т “Салбарын хүний нөөц-Нийгмийн хамгаалал зорилтын хүрээнд алба хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлж, орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлж, тогтвор суурьшилтай ажиллах баталгааг дээшлүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, тэдгээрийн зохистой харьцааг

		<p>хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэгдэж байгаа төгсөгчидийн тоо, чанарт нарийвчлан судалгаа хийх, бодит хэрэгцээ шаардлагыг гаргах шаардлагатай байна.</p> <p>Мөн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ХХМТ-ийн салбарын мэргэжилтэй мэргэжилтнүүдийг бэлтгэх талаар цаашид төрөөс баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах хэрэгцээ шаардлага нэн тэргүүнд тулгарч байна.</p>
5.	Зөвлөх үйлчилгээний зорилго	<p>Монгол Улсын дунд болон урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд ХХМТ-ийн салбарын хүний нөөцийн судалгааг хийж, бодлогын баримт бичгийн төсөл боловсруулна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Салбарын хүний нөөцийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох /өргөн нэвтрүүлэг, радио, шуудан, кибер аюулгүй байдал, өгөгдлийн шинжээч гэх мэт мэргэжлийн чиглэл тус бүрээр/;</li> <li>2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр хүний нөөцөө бэлтгэж буй 5-н улс орны сайн туршлагыг судлах /өргөн нэвтрүүлэг, радио, шуудан, кибер аюулгүй байдал, өгөгдлийн шинжээч гэх мэт мэргэжлийн чиглэл тус бүрээр/;</li> <li>3. Эрэлтэд нийцсэн богино, дунд болон урт хугацаанд хүний нөөцийг бэлтгэхэд тулгарч болзошгүй хүндрэл бэрхшээлийг судлан дүгнэлт, зөвлөмж боловсруулах;</li> <li>4. Хүний нөөцийг хөгжүүлэхэд баримтлах дунд болон урт хугацааны бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах.</li> </ol>
6.	Зөвлөх багт болон гишүүдэд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Судалгаа, шинжилгээ хийх чиглэлийн хуулийн этгээд байх;</li> <li>- Хуулийн этгээдийн танилцуулга, гэрчилгээний хуулбар;</li> <li>- Сүүлийн 2 жилд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын туршлагын талаарх мэдээлэл /Хүний нөөцийн эрэлт нийлүүлэлтийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага/</li> <li>- Зөвлөх баг нь ажлын байр, хаяг, утастай байх;</li> <li>- Зөвлөх баг нь 4-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байна;</li> <li>- Зөвлөх багийн хүний нөөцийн чадавхын талаарх мэдээлэл /голлох ажилчдын ур чадварын мэдээлэл, туршлага, мэргэжлийн дипломын хуулбар, бүтээлийн жагсаалт/</li> </ul>

7.		<p>Зөвлөхийн багийн гишүүд дараах шаардлагыг хангасан байна:</p> <p><b>Багийн ахлагч:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Зөвлөх багийн ахлагч нь Мэдээлэл технологийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх;</li> <li>- Судалгааны чиглэлээр 5-аас дээш жил ажилласан туршлагатай байх;</li> <li>- Судалгааны үр дүнг олон улсын мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд сүүлийн 2-оос дээш жил хэвлүүлсэн байх;</li> <li>- Судалгаа, анализ, дүгнэлт хийх өндөр чадвартай байх.</li> <li>- Ижил төрлийн ажлыг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан туршлагатай байх.</li> </ul> <p><b>Багийн гишүүд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүний нөөцийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, бизнесийн удирдлага, бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх;</li> <li>- Хүний нөөцийн эсвэл судалгааны чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан байх;</li> <li>- Судалгаа, анализ, дүгнэлт хийх, шинэ санаа дэвшүүлэх, арга зүй боловсруулах чадвартай байх;</li> <li>- Ижил төрлийн судалгаа хийж байсан туршлагатай байх.</li> </ul>
8.	Зөвлөх багийн үндсэн үүрэг	<ul style="list-style-type: none"> <li>- Захиалагчтай тогтмол харилцах;</li> <li>- Судалгааны төлөвлөгөөг гаргаж захиалагчаар баталгаажуулах;</li> <li>- Бодлогын зөвлөмжийн эх сурвалж, үнэн зөв байдлыг бүрэн хариуцах;</li> <li>- Судалгааны тайлан болон бодлогын баримт бичгийн төслийг тогтоосон хугацаанд нь ирүүлэх.</li> </ul>
9.	Тайлангийн үе шат	<p><u>Дунд хугацааны тайлан:</u> Гэрээ байгуулснаас хойш 25 хоногийн дотор буюу 2024 оны ....р сарын ....-ны өдөр дараах ажлуудыг гүйцэтгэн захиалагч талд танилцуулах. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- ХХМТ-ийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага, эрэлт нийлүүлэлтийн судалгаа, бүлгийн дүгнэлт;</li> <li>- Олон Улсын сайн туршлагын судалгаа, бүлгийн дүгнэлт.</li> </ul>
10.		<u>Эцсийн тайлан:</u>

Гэрээ байгуулснаас хойш 45 хоногийн дотор буюу 2024 оны...-р сарын...-ны өдөр дараах ажлуудыг гүйцэтгэн захиалагч талд хүлээлгэн өгнө. Үүнд:

- Салбарын хүний нөөцийг богино, дунд болон урт хугацаанд бэлтгэх, цаашид тулгарч болзошгүй хүндрэл, бэрхшээлийг хэрхэн даван туулах боломж, олон улсын туршлага, нэгдсэн зөвлөмж дүгнэлт;

- Хүний нөөцийг хөгжүүлэхэд баримтлах дунд болон урт хугацааны бодлогын баримт бичгийн төсөл.

- Гүйцэтгэсэн ажлын талаар товч тайлан.

ТАНИЛЦСАН:

СШХ-ИЙН ДАРГА

О.ГЭРЭЛХҮҮ

БОЛОВСРУУЛСАН:

БТГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Д.СЭЛЭНГЭ